



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь  
нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт  
оруулах зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 8, 5.3 дугаар зүйлийн 1, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.47, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ОЧУН ҮЦК” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “ОЧУН ҮЦК” ХХК (Г.Оргил)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН